



Улс орнуудын асуулт хариулт

Доорх асуулт хариултуудыг улс орнуудын МСК-аас туслалцаа хүсэх саналаа цаашид боловсруулахад зааварчилгаа болгох зорилгоор зохиожээ. МСК-ийн багийнхан эдгээр асуултыг болзол хангасан 16 улс оронд 2004 оны 5, 6-р сард аялж байхдаа хүлээн авсан асуултууд дээрээ үндэслэн бичсэн байна.

Гэрээний үүрэг юу вэ?

Гэрээ гэдэг нь тухайн улсын мянганы сорилтын сангийн хөтөлбөрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх болон хянах үндсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг дэмжихэд МСК хийгээд тухайн улсаас зарцуулагдах хөрөнгө, МСК ба тухайн улсад ноогдох бусад хариуцлагыг тусгасан МСК, тухайн улс хоёрын хоорондох тохиролцол юм. Гэрээнд хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, үнэлгээ зэрэг нэмэлт нарийн асуудлыг тусгасан бусад гэрээ хэлцлийг хавсаргаж болно. Гэрээний талаарх бусад нэмэлт шаардлагууд нь МСК-ийн хууль ёсны эрх болох 2003 оны Мянганы Сорилтын Хуулийн 609 дүгээр заалтад бий.

Гэрээнээс хөрөнгө чухам хэрхэн гарах вэ?

МСК нь Гэрээний эхнээс л хүлээн авагч улстай хийсэн олон жилийн хэлэлцээрийг бүрэн санхүүжүүлэх эрхтэй бөгөөд зохистой цагт нь эхлэхийг хичээх болно. МСК-ийн хөрөнгийг МСК-ийн хөтөлбөрийн санхүүжилтийг хариуцах эрхтэй захиргааны нэгжүүдийн хэрэгцээ болон ажлын үзүүлэлтэд тулгуурлан Гэрээний хугацаанд тодорхой үе шаттайгаар зарцуулна. Олон тохиолдолд тухайн нэгж нь засгийн газар биш байж болох бөгөөд энэ талаар санхүүгийн хариуцлагын тухай ярихад дахин авч хэлэлцэх болно.

Туслалцаа хүсэх санал болон тухайн улс, МСК хоёрын хооронд тогтоосон Гэрээний ялгаа юу вэ?

Сонгогдсон улс бүр МСК –д туслалцаа хүссэн санал гаргах эрхтэй бөгөөд энэ талаарх гол асуудлуудыг МСК-аас 4 сарын 30-нд хэвлүүлсэн “Мянганы Сорилтын Дэмжлэг авах санал боловсруулах удирдамж – 2004 Санхүүгийн жил” хэмээх баримтад тодорхойлсон байна. Товчхондоо, санал нь доорх зүйлсийг авч хэлэлцэх ёстой. Үүнд: а. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах замаар ядуурлыг бууруулах эн тэргүүний алхмууд, б. Эдгээр чухал алхмыг хэрхэн тодорхойлох, в. Тэдгээр алхмуудад зориулсан төлөвлөгөө, тэрхүү төлөвлөгөө нь бусад донор хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдах, г. Эдгээр арга хэмжээний ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөө, д. Ядуурлыг бууруулах ажлын явц хийгээд бэрхшээлийг давах үйл ажиллагааг тоон хэмжүүрээр хэрхэн хэмжих, е. Цаашид бодлогоо сайжруулах төлөвлөгөө. Саналд мөн санал боловсруулах үед асуудлыг авч хэлэлцсэн процессийг дэлгэрэнгүй оруулна.

Зөвлөлдөн, тохиролцсоны дараа МСК болон тухайн улс хоёр Гэрээ байгуулна.

Тухайн улс МСК-тай хэзээнээс эхлэн зөвлөлдөх вэ?

МСК-ийн дэмжлэг хүссэн санал болон МСК-ийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг тодотгох үүднээс тухайн улс МСК-тай зөвлөлдөх ажилд орохыг аль болох эртнээс эхлэхийг дэмжих болно.

МСК нь Гэрээний боловсруулалтыг тухайн улсыг хөгжүүлэх үр нөлөөтэй хөтөлбөр боловсруулахад МСК болон тухайн улсын хамтран оролцсон үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд энэ талаарх гол асуудлуудыг “Мянганы Сорилтын Дэмжлэг авах санал боловсруулах удирдамж – 2004 оны Санхүүгийн жил” баримтад дурьдсан байгаа. Улс орнууд саналын талаарх үзэл бодлоо албан ёсны санал гарахаас бүр өмнө ч МСК-тай зөвлөлдөж болно. Эрт хэлэлцсэн зөвлөгөөн нь цаашид саналыг салбар бүрээр боловсронгуй болгоход туслах болно.

Саналыг хэдэн удаа гаргаж болох вэ?

Ямар ч улс ганц удаа, эсвэл бүр дараалан олон удаа санал гаргасан эсэхээрээ хасагдах үндэсгүй. Гол нь тухайн улс санал гаргасан хөтөлбөрөө улам сайжруулснаа тодорхой үзүүлэх, МСК-тай харилцан тохирсон Гэрээнийхээ дагуу шударга ажиллаж буйгаа илэрхийлэх хэрэгтэй. Зарим улс бусад улстай харьцуулахад санал боловсруулах үйл ажиллагаандаа илүү цаг зарцуулах хэрэгтэйг МСК ойлгоно.

Тухайн улс болон МСК-ын зөвлөгөөн хаана, хэрхэн болох вэ?

МСК нь тухайн улсыг зөвлөлдөх газраа тодорхойлохыг хүсэхийн сацуу тухайн улсад өөрсдийн газраа нэрлэнэ. Тухайн газар нь МСК-ийн болон тухайн улсын албаны хүмүүсийн уулзалтыг зохион байгуулна.

Хэр их зөвлөлдөх хэрэгтэй вэ?

Тухайн улсын саналаа боловсруулах үйл ажиллагаанд хэр их зөвлөгөөн хэрэгтэй болох талаар ямар нэг тоон хэмжээс болон зөвлөлдөх тодорхой арга зүй, хэлбэр зэргийг МСК тогтоохгүй. МСК-ийн хууль, эрх зүй нь сонгогдсон улсын засгийн газраас орон нутгийн хэтийн төлөв, хот хөдөөгийн ядуу өрх болон эмэгтэйчүүдийг саналдаа тусгах, хувийн хэвшлийн болон сайн дурын байгууллагууд, бизнесийн бүлэг, донор байгууллагуудтай хэлэлцэхийг шаардах болно. МСК нь эдгээр болон бусад бүлгүүдтэй орон даяар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хэлэлцүүлэг хийхийг зөвлөж байна. МСК нэгдмэл нэг саналыг хайгаагүй, жинхэнэ “тохиролцоо” гэдэг нь үргэлж бололцоотой байдаггүй гэдгийг мэднэ. Харин энэхүү хэлэлцүүлэг нь хэлбэр төдий бус үр ашигтай байж, улс орны нэн тэргүүний хэрэгцээг гаргаж ирэхийг хүсэн хүлээнэ.

Улс орнууд санал боловсруулахдаа USAID болон АНУ-ын бусад төрийн байгууллагыг оролцуулж болох уу? Гэрээний зорилго, зорилтуудыг улам тодорхой болгох үүднээс АНУ-ын засгийн газраас техникийн шинэ тусламж ирэх үү?

МСК нь сонгогдсон улс тогтвортой хөгжих болон ядуурлыг бууруулах анхдагч алхмуудаа өөрсдөө тодорхойлж чадна гэдэгт итгэж буй, санал боловсруулах үйл ажиллагаа ч үүнтэй адил. Нэмж хэлэхэд санал нь мэдээллийн хэрэгслээр нийгэм даяар цацагдсан байх ёстой. Сонгогдсон улсад анхдагч алхмаа өөрсдөө тодорхойлох боломж олгох үүднээс АНУ-ын байгууллагуудаас үүнд оролцохгүй байх, саналд ямар нэгэн анхдагч хэрэгцээг зааж өгөхгүй байхыг хүсэх болно. (Харин МСК нь АНУ-ын засгийн газрын нэгжүүдийн Саналтай холбогдох бодол санаа болон тухайн улстай холбогдох бусад олон асуудлыг авч үзнэ.)

Санал боловсруулах, анхдагч алхмаа тодорхойлох анхан шатны үйл ажиллагаанд АНУ-ын Засгийн газраас техникийн тусламж үзүүлэх нь тухайн улсын хэрэгт хөндлөнгөөс оролцох хэрэг болох тул ерөнхийдөө үл дэмжинэ. Харин тухайн улс АНУ-ын төрийн бус эх сурвалжийн хөрөнгөөр ямар нэгэн өөр нэгж байгууллагаас техникийн туслалцаа авахыг МСК буруушаахгүй.

Хэрвээ сонгогдсон улст АНУ-ын төрөөс санхүүжсэн ямар нэг хөтөлбөр, төсөл бүр өмнөөс нэн чухал хэрэгцээг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг үнэлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа бол цаашдын үйл ажиллагаа, хамтран ажиллах боломжийн талаар МСК болон тухайн төслийн удирдагч нартай зөвлөлдөнө үү.

МСК-д гаргах Саналыг боловсруулах ажилд тухайн улс хэнийг оролцуулах вэ? Дотоодын зөвлөх үү? Гадаадын зөвлөх үү? Дотоодын ТББ уу? Гадаадын ТББ уу? UNDP мэт гадаадын донор, эсвэл 2 талын гэрээт болон олон улсын байгууллага уу? Зөвлөгөө дэмжлэгийг цалинжуулах (улсаас, эсвэл гуравдагч талаас) болон цалингүй ажиллахын ялгаа бий юу?

МСК нь Саналд тухайн улсын төлөөлөл илүү байхыг дэмжих, “нарийн дэд бүтэц” (мэргэжлийн болон задлан шинжлэх чадвар) – ийн хөгжлийг дэмжих зорилгоор санал боловсруулах ажиллагаанд өөрийн улсын иргэд, эх сурвалжийг оролцуулахыг зөвлөнө. Гэвч МСК нь гэрээний ажилтан оролцохыг хориглохгүй бөгөөд уг ажилтны тухайн улсаас цалинждаг болон цалингүй байх эсэхээр нь ялгаварлан үзэхгүй. Харин ийм эх сурвалжийг ашигласнаа МСК-д мэдээлэх хэрэгтэй.

Гол нь засгийн газар Саналаа яг өөрсдөө, баттай эзэмшиж, нийгмийн өргөн хүрээнд үр ашигтай хэлэлцсэний дараа боловсруулах хэрэгтэй. Ингээгүй тохиолдолд МСС-аар нухацтай хэлэлцэгдэхгүй.

Гэрээг эцэслэн тогтооход АНУ-аас техникийн тусламж ирэх боломж бий юу? Бий бол хэзээ?

МСС-д гаргасан тухайн улсын саналыг хэлэлцэх үед хөтөлбөрийн зорилгыг биелүүлэх тодорхой арга хэмжээнүүдийн үнэ цэнэ, нөхцөл боломжийг тодорхойлоход зориулан техникийн туслалцаа гаргаж болох бөгөөд энэ тусламж нь ялангуяа тухайн улс тийм үйлчилгээг өөр арга замаар олж чадахгүйгээ илэрхийлж чадвал илүү бололцоотой. Нэмж өгүүлэхэд, тусламж нь Саналын эдийн засгийн учир шалтгаан, санхүүгийн удирдлага, инженерийн боломж, үнийн бодлого, хяналт үнэлгээ, төлөвлөгөөний хэрэгжилт болон мэнэжментэд зориулагдаж болно. Энэ шийдвэрийг МСК тухайн улстай асуудал нэг бүрээр зөвлөлдөж байж гаргана.

Гэрээнд хяналт, үнэлгээний ямар суурь асуудлыг оруулах вэ?

Хяналт үнэлгээний төлөвлөгөө МСС-ийн батлагдсан Гэрээ болгонд байх бөгөөд тэр нь тухайн улсын эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн амжилтыг хэмжих ажиллагааны үндсийг тавьж өгнө.

Хяналт үнэлгээний төлөвлөгөө нь тухайн улсын ерөнхий зорилго болон тэр зорилгод хүрэхэд шаардлагатай дунд шатны зорилтуудыг тодорхойлох хэрэгтэй. Төлөвлөгөөнд мөн дэвшлийг хэмжиж болохуйц үндсэн өгөгдлүүд, үйл ажиллагааны чадварын үзүүлэлтийг оруулна.

Гүйцэтгэлийн явцад эдгээр хэмжигдэхүүнүүд нь хөтөлбөрийн удирдагчид тусгай хөтөлбөр бүрийн үзүүлэлтийг үнэлэн дүгнэх, хэрэгцээтэй бол өөрчлөн солиход нь тусална. Эдгээр хэмжигдэхүүн нь мөн үйл ажиллагааны үзүүлэлтийг гаднаас хянахад тус болно.

Төлөвлөгөө нь мөн өгөгдлүүдийг цуглуулах, асуулга явуулах арга зүйд үндэслэн, үр нөлөөг нарийн үнэлэх процессийг тодруулах хэрэгтэй. МСК-ын хөтөлбөрийн үйл ажиллагаануудын албан ёсны үнэлгээ болон үр дүнгийн үнэлэлт нь санал болгосон тусгай хөтөлбөр бүрээс шалтгаалсан өөр өөр хэлбэртэй байж болно. Хөтөлбөр амжилттай, амжилтгүй болсон эсэх, хөтөлбөр үр дүнд хүрэхэд үнэ хөлсний талаар хамгийн зөв ажиллаж чадсан эсэх зэргийг үнэлгээ нь хөндөж болно.

Тусгай үйл ажиллагаануудын үр дүнг илүү сайн ойлгох зорилгоор МСК болон тухайн улс хамтарсан туршилт, гэнэтийн сорилт хийж болно. Тодорхой хэмжүүр, үйл ажиллагааны үзүүлэлтийг хянах суурь зэргийг тогтоох нь албан үнэлгээ болон үр дүнгийн үнэлэлтийг удирдахад чухал мэдээллээр хангаж өгнө.

Улс орнууд хөрөнгө оруулалтын хариуцлагын талаар ямар стандарт шаардлага хүлээх вэ?

Гэрээ бүр МСК-ийн хөтөлбөрийн хөрөнгийг захиран зарцуулах нэгж, газар, байгууллагыг заасан санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөг агуулах ба үүнд мөн нягтлан бодох, зарцуулах болон бэлтгэн нийлүүлэх менежментийг нарийн заасан байна.

МСС-ийн менежмент болон АНУ-ын татвар төлөгчдийн доллараар санхүүжсэн нэгжүүд хуулийн шаардлагатай тулгарна. МСК нь тухайн улсын хүсэлт гаргасан санхүүгийн төлөвлөгөөг эргэн үзэж, холбогдох нэгж, газар, байгууллагуудын чадавхийг харгалзан ажиллана.

Олон төрлийн механизм ашиглаж болно. Зурагтай үзүүлэн нь санхүү, бүртгэл тооцооны газар, засгийн газрын менежментийн систем, Гэрээний хөрөнгийг төрөөс зохицуулан санхүүгийн менежментийн тусгай салбаруудыг үндэслэх ажилд болон бие даасан оролцогч тал МСК-ийн хөрөнгийг хэрхэн зарцуулж буйг харж итгэх зэрэгт тустай юм.

Хүсэлт гаргасан нэгж, газар, байгууллагуудыг үнэлэхдээ МСК нь доорх зүйлсийг шалгана.

Хөрөнгийн хяналт шалгалт ба баримт бичиг
Үүрэг хариуцлагын тусгаарлалт ба дотоод хяналт
Данс тооцооны тогтвортой арга, стандарт, систем
Хугацаанд нь үр дүнтэй тайлагнах чадвар
Санхүүгийн бүх мэдээллийг нийтэд цагт нь үр дүнтэй хүргэх дадал
Бэлэн мөнгөний менежментийн дадал
Мөнгийг цагт нь төлдөг байдал
Нийлүүлэх, гэрээлэх дадал, нийлүүлэлтийг боломжтой бол бүгдийг ил хийх
Аудитын төлөвлөгөө

Улс орнууд Саналдаа хүлээн авах үр ашгаа оруулахын учир юу вэ?

МСК-ын тусламж хүсэх санал нь тухайн улсын ард иргэд өргөн олноороо ядуурлаас гарч, эдийн засаг нь өсөх зорилгыг тодорхойлсон байх ёстой. Улс орнууд энэхүү зорилгоо хэрхэн гүйцэлдүүлэхээ, ямар үр ашиг хүртэхээ болж өгвөл орлогын түвшин, хүйс, насаар нь салган оруулах ёстой. Ингэхийн тулд улс орнууд хүсэлт гаргасан хөтөлбөр нь тэдний гол хүрч нөлөөлөх гэсэн хүн амын бүлэглэлд хэрхэн нөлөөлөхийг задлан шинжлэх хэрэгтэй. Тухайн улсын саналыг үнэлээд МСК хүссэн хөтөлбөр нь зорьсон үр ашигт нь хүрч чадах эсэхийг шийднэ.

Гэрээний дагуу хамтран ажиллах улсын хувь нэмэр юу вэ?

Хэдийгээр хамтран ажиллаж буй улс орнуудын санхүүжилт тухайн орнуудаас хэрэгжүүлж буй хөтөлбөртөө эзэн болоход маш чухал боловч энэ удаа улс орнуудаас ямар нэгэн тусгай хувь нэмэр шаардаагүй.

2006 оноос эхлэн МСК-ын хууль эрх зүйн бичигт болзол хангасан бага-дунд орлоготой улс орнууд үндэснийхээ төсөвт харьцангуйгаар хувь нэмэр оруулахаар заагдсан байгаа.

Болзол хангасан бүх улс сангаас хүртэх үү?

Үгүй, Сангаас хүртэхийн тулд болзол хангасан улс эдийн засгийн өсөлтөөр ядуурлыг бууруулах зорилготой Гэрээг МСК-тай хийх ёстой. Хэрвээ тухайн улс МСК хоёр Гэрээгээр тохиролцоонд хүрч чадахгүй бол тухайн улс сангаас хүртэхгүй.

МСК болзол хангасан улсуудад тодорхой хэмжээний хөрөнгийг хуваарилах үү?

МСК нь хөрөнгөний хэмжээ хуваарилах системгүй. МСК нь тухайн улсын эдийн засгийн далайц, хүн амын тоо, бусад донор хөрөнгийг тооцоолон, МСК-ийн тухайн улс дахь хөтөлбөрийн цар хүрээ, мөнгөний шаардлагаас шалтгаалан, үйл ажиллагаа тус бүрээр нь хуваарилалтыг шийднэ. Тухайн улсын өөрсдийнх нь үнийн тооцооны баримтын чанар нь МСК-ийн улсын саналыг үнэлэх үнэлгээнд нөлөөлж Гэрээний тохиролцоог хэр хурдан болохыг зааж өгч болно.

МСК-ийн сонгосон шалгуурын цаашдын үүрэг юу вэ?

Болзол хангасан орнууд цаашид бодлогын салбартаа (шударга удирдах, ард түмэнд хөрөнгө оруулах, эдийн засгийн эрх чөлөөг тэтгэх) үйл ажиллагааны үр дүнгээ сайжруулахаар үргэлжлүүлэн ажиллаж МСК арван зургаан зааварлагч хэмжүүр тогтооно. МСК мэдээж тухайн улсад учирч болох бүхий л хүндрэлийг шалгаж үзнэ, гэхдээ хэн нэгэн зааварлагчийн ноцтой саналаар санхүүжилтийг зогсоож болно. Энэ шаардлагыг МСК тухайн улс хоёрын Гэрээнд зааж өгнө.

Гэрээ байгуулсан улсын санхүүжилт ямар нөхцөлд зогсож болох вэ?

Гэрээ байгуулсны дараа тухайн улс болон тодорхой нэгж Гэрээн дэх хариуцлагаа биелүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг зогсоох болон хойшлуулж болно. Гэрээг бүхэлд нь болон хэсэг хэсгээр цуцлах, хойшлуулж болох шалтгаан нь доорх үйлдлүүд байж болно. Үүнд: Гэрээнд зааснаар тохирсон үр дүнд хүрээгүй, МСК-иас заасан үзүүлэлтүүд буурсан буюу түүнд тохирохгүй үйл ажиллагаа явуулсан гэх мэт. Гэхдээ эдгээрээс өөр шалтгаан байхгүй гэсэн үг бас биш.